

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БӨА-2023/04/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: У.Ербол

Утас: 94159291 Цахим хаяг: ainurm@ audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>4</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....</b>	<b>6</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>10</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>13</b>
<b>4.1 Ерөнхий зүйл .....</b>	<b>13</b>
<b>4.2 Материаллаг байдал.....</b>	<b>13</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....</b>	<b>13</b>
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>13</b>
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....</b>	<b>14</b>
<b>4.5.1 Завсрын аудитын талаар .....</b>	<b>14</b>
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....</b>	<b>14</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>14</b>
Аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна. ....	14
<b>5.1 Төлбөрийн акт .....</b>	<b>14</b>
<b>5.2 Албан шаардлага .....</b>	<b>14</b>
<b>5.3 Зөвлөмж .....</b>	<b>14</b>
Байхгүй .....	14
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>14</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
НИСЭХ БУУДЛЫН ДАРГА  
К.ЕРЖАН ТАНАА

2023.08.13 № 228  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

#### Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	14,943,720.45	12,763,839.53
1.1.2	Дансны авлага	7,221,857.13	11,462,276.49
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0	53,500.01
1.1.4	Бусад авлага	61,699.40	
1.1.6	Бараа материал	171,670,777.50	119,737,237.37
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>193,898,054.48</b>	<b>144,016,853.40</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,949,324,956.34	9,264,143,524.01
1.2.2	Биет бус хөрөнгө	7,287,555,000.49	7,321,647,942.14
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	41,161,546.18	40,072,933.18
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>16,278,041,503.01</b>	<b>16,625,864,399.33</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,471,939,557.49</b>	<b>16,769,881,252.73</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1.1.3	Татварын өр	20,000.00	32,246.40
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	278,000.00	
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>298,000.00</b>	<b>32,246.40</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>298,000.00</b>	<b>32,246.40</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>7,939,790,829.94</b>	<b>8,339,269,996.91</b>
2.3.1	Өмч: - төрийн	7,284,500,000.00	7,284,500,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	655,290,829.94	1,054,769,996.91
2.3.9	Хуримтлагдсан ашиг	8,531,850,727.55	8,430,579,009.42
	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>16,471,641,557.49</b>	<b>16,769,849,006.33</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>16,471,939,557.49</b>	<b>16,769,881,252.73</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	14,028,008.96	23,032,060.96
2	Борлуулалтын өртөг	1,683,714,680.58	1,705,702,906.15
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>-1,669,686,671.62</b>	<b>-1,682,670,845.19</b>
8	Бусад орлого	1,365,821,706.55	1,678,476,981.42
10	Ерөнхий ба удирдлагын зардал	0	800,000.00
12	Бусад зардал	80,285,205.28	96,277,854.36
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>-384,150,170.35</b>	<b>-101,271,718.13</b>
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-384,150,170.35</b>	<b>-101,271,718.13</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>-384,150,170.35</b>	<b>-101,271,718.13</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>-384,150,170.35</b>	<b>-101,271,718.13</b>

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл						
9	2021 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл	7,284,500,000.00	0	655,290,829.94	0	8,531,850,727.55	16,471,641,557.49
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0	0	0.00
11	Залруулсан үлдэгдэл	7,284,500,000.00	0	655,290,829.94	0	8,531,850,727.55	16,471,641,557.49
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0	-101,271,718.13	-101,271,718.13
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	399,479,166.97	0	0	399,479,166.97
15	Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0	0.00
17	2022 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл	7,284,500,000.00	0	1,054,769,996.91	0	8,430,579,009.42	16,769,849,006.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		0
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,152,675,553.85	1,106,660,536.66
1.2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,080,990.85	19,443,536.66
	Татаас, санхүүжилтийн орлого	1,151,594,563.00	1,087,217,000.00
	Мөнгөн зарлагын дүн (-)	1,155,160,476.03	1,108,840,417.58
1.3	Ажиллагчдад төлсөн	554,918,464.17	612,165,097.55
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	172,261,068.24	165,294,562.37
	Бараа материал худалдан авахад төлсөн	244,259,361.58	193,964,453.46
	Ашиглалтын зардалд төлсөн	25,794,996.00	33,518,464.40
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	836,000.00	3,850,000.00
	Татварын байгууллагад төлсөн	147,182,376.94	91,763,140.00
	Даатгалын төлбөрт төлсөн	6,898,000.00	6,898,300.00
	Бусад мөнгөн зарлага	3,010,209.10	1,386,399.80
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,484,922.18	-2,179,880.92
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-2,484,922.18	-2,179,880.92

Баян-Өлгий аймгийн Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,428,642.63	14,943,720.45
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,943,720.45	12,763,839.53

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Мянган төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны тодотгол	2022 оны тодотгол	2022 оны гүйцэтгэл	Хэмнэлт хэтрэлт	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>1,251,806.7</b>	<b>1,344,251.40</b>	<b>1,108,840.4</b>	<b>235,411.0</b>	<b>82.5</b>
<b>НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,251,806.7</b>	<b>1,344,251.4</b>	<b>1,108,840.4</b>	<b>235,411.0</b>	<b>82.5</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,241,302.6</b>	<b>1,326,841.40</b>	<b>1,101,823.9</b>	<b>225,017.5</b>	<b>83.0</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>798,956.0</b>	<b>820,298.30</b>	<b>665,564.8</b>	<b>154,733.5</b>	<b>81.1</b>
Үндсэн ба нэмэгдэл цалин	695,006.0	726,281.30	571,104.90	155,176.4	78.6
Унаа хоолны хөнгөлөлт	103,950.0	94,017.00	94,459.85	(442.8)	100.5
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>111,853.8</b>	<b>102,537.20</b>	<b>89,729.16</b>	<b>12,808.0</b>	<b>87.5</b>
Тэтгэврийн даатгал	71,906.0	69,725.40		69,725.4	-
Тэтгэмжийн даатгал	7,989.6	8,204.80		8,204.8	-
ҮОМШ-ийн даатгал	14,381.2	6,562.40		6,562.4	-
Ажилгүйдлийн даатгал	1,597.9	1,640.60		1,640.6	-
Эрүүл мэндийн даатгал	15,979.1	16,404.00		16,404.0	-
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,162.0</b>	<b>48,434.30</b>	<b>46,238.3</b>	<b>2,196.0</b>	<b>95.5</b>
Гэрэл, цахилгаан	14,949.0	15,660.00	13,467.31	2,192.7	86.0
Түлш, халаалт	17,664.0	30,791.80	30,791.00	0.8	100.0
Цэвэр, бохир ус	2,549.0	1,982.50	1,980.00	2.5	99.9
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>47,233.8</b>	<b>75,602.60</b>	<b>75,277.6</b>	<b>325.0</b>	<b>99.6</b>
Бичиг хэрэг	2,635.8	1,144.30	1,907.25	(763.0)	166.7
Тээвэр, шатахуун	32,544.4	59,949.50	60,846.30	(896.8)	101.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,918.0	5,127.90	5,006.42	121.5	97.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,423.0	6,165.40	5,676.70	488.7	92.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,712.6	3,215.50	1,840.90	1,374.6	57.3
<b>Нормативт зардал</b>	<b>11,475.2</b>	<b>17,860.00</b>	<b>17,781.0</b>	<b>79.0</b>	<b>99.6</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,475.2	17,860.00	17,781.00	79.0	99.6
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>104,991.0</b>	<b>127,978.50</b>	<b>86,655.9</b>	<b>41,322.6</b>	<b>67.7</b>
<b>Багаж, техник, хэрэгсэл</b>	<b>69,026.0</b>	<b>87,713.50</b>	<b>55,435.5</b>	<b>32,278.1</b>	<b>63.2</b>
Тоног төхөөрөмж	33,038.0	36,901.70	19,120.05	17,781.7	51.8
Автомашин	9,082.0	9,044.30	7,895.50	1,148.8	87.3
Аэродром	5,223.0	13,202.50	7,879.90	5,322.6	59.7

Баян-Өлгий аймгийн Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Гал унтраах зардал	21,683.0	28,565.00	20,540.00	8,025.0	71.9
<b>Хөдөлмөр хамгааллын зардал</b>	<b>10,900.0</b>	<b>11,200.00</b>	<b>8,831.40</b>	<b>2,368.6</b>	<b>78.9</b>
<b>Урсгал засвар</b>	<b>25,065.0</b>	29,065.00	22,389.08	<b>6,675.9</b>	<b>77.0</b>
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>26,383.9</b>	<b>25,000.00</b>	<b>16,735.5</b>	<b>8,264.5</b>	<b>66.9</b>
Дотоод албан томилолт	26,383.9	25,000.00	16,735.50	8,264.5	66.9
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>105,247.0</b>	<b>109,130.50</b>	<b>103,841.6</b>	<b>5,288.9</b>	<b>95.2</b>
Харуул, хамгаалалтын зардал	3,650.0	9,100.00	4,126.50	4,973.5	45.3
Үл хөдлөх хөрөнгийн татвар	78,600.0	77,012.80	77,012.80	-	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	790.0	810.00	800.00	10.0	98.8
Даатгалын үйлчилгээ	6,898.0	6,898.30	6,898.30	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	597.0	597.40	346.34	251.1	58.0
Газрын төлбөр	14,568.0	14,568.00	14,569.00	(1.0)	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	144.0	144.00	88.70	55.3	61.6
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,030.0</b>	<b>6,700.0</b>	<b>2,296.6</b>	<b>4,403.5</b>	<b>34.3</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	1,030.0	5,700.00	1,716.55	3,983.5	30.1
<b>Сургалт семинар</b>	<b>1,000.0</b>	<b>1,000.0</b>	<b>580.0</b>	<b>420.0</b>	<b>58.0</b>
Дотоод сургалт	1,000.0	1,000.00	580.0	420.0	58.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,474.1</b>	<b>10,710.0</b>	<b>4,720.0</b>	<b>5,990.0</b>	<b>44.1</b>
<b>Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг</b>	<b>8,474.1</b>	<b>10,710.0</b>	<b>4,720.0</b>	<b>5,990.0</b>	<b>44.1</b>
Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж	6,820.0	9,225.00	3235	5,990.0	35.1
Эмчилгээний төлбөр	1,654.1	1,485.0	1,485.0	-	100.0

<b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>90,870.0</b>	<b>15,000.0</b>	<b>19,443.5</b>	<b>(4,443.5)</b>	<b>129.6</b>
Буулт, хөөрөлтийн орлого	20,220.0	5,000.0	19,373.5	(14,373.5)	387.5
Зорчигч үйлчилгээний орлого	16,750.0	4,500.0		4,500.0	-
Бусад орлого	53,900.0	5,500.0	70.0	5,430.0	1.3
Дээд шатны захирагчаас санхүүжих		1,344,251.4	1,087,217.0	257,034.4	80.9

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа**

Баян-Өлгий аймгийн Өлгий Нисэх буудлын зорилго нь нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг найдвартай хангаж, үйлчлүүлэгчдийг дээдэлсэн чанартай, соёлтой, тав тухтай үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд иргэний нисэхийн зорилтот тогтолцоог бүрдүүлж, аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг хэрэгжүүлэх, үйлчлүүлэгчдийг дээдэлсэн аюулгүй, эрүүл тохилог, үр ашигтай ажиллах зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд эдийн засгийн үр ашигтай агаарын навигацийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, удирдан чиглүүлэх, зохион байгуулалтаар хангах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Иргэний Нисэхийн үндэсний төв, Төрийн өмчит ААТҮГ Өлгий Нисэх буудал гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

#### **3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин**

Өлгий Нисэх буудал нь, Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Өлгий Нисэх буудал төрийн өмчит ААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Иргэний нисэхийн Ерөнхий газрын даргын 2021 оны А/124 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн батлах тухай журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Өлгий Нисэх буудал төрийн өмчит ААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 297.8 сая төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14,943,7	12,763,8	-2,179.9
Авлага	7,283.5	11,515.7	4,232.2
Бараа материал	171,670,7	119,737,2	-51,933.5
Үндсэн хөрөнгө	16,278,041.5	16,625,864.4	347,822.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>16,471,939,5</b>	<b>16,769,881,3</b>	<b>297,941.8</b>
Өр төлбөр	298,0	32,2	-265.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	16,471,641.5	16,769,849.0	298,207.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>16,471,939,5</b>	<b>16,769,881,3</b>	<b>297,941.8</b>

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2.1 сая төгрөгөөр, бараа материалын дансны үлдэгдэл 51.9 сая төгрөгөөр, өр төлбөр дансны үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын данс нь өмнөх оноос 51.9 сая төгрөгөөр буурсан нь бусад аймгуудын нисэх буудлуудад хоорондын тооцоогоор түлш, шатахууныг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 347.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ИНЕГ-аас нийлүүлсэн тоног төхөөрөмж болон үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Өлгий Нисэх буудлын тайлант онд батлагдсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2.5-д хавсаргав.

Гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 154.2 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 12.8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2.2 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 0.3 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 41.3 сая төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын зардлыг 2.4 сая төгрөгөөр, томилолт, зочны зардал 8.3 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 5.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4.4 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 6.0 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус газрын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2022 оны А/286/218 тоот хамтарсан тушаалаар баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 15.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,344,2 сая төгрөгөөр баталж, 1,329.2 сая төгрөгийг гүйцэтгэлийн санхүүжилтээр олгохоор төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,701.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,802.8 сая төгрөгийн зардал гарган, 101.2 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 19.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 4.4 сая төгрөг өөр буюу 29.3 хувиар давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,108.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 235.4 сая төгрөг буюу 17.6 хувиар дутуу байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани/ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 22 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,763.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 17.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Баян-Өлгий аймгийн Нисэх буудал нь тайлант онд төсвөө 235.4 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан, алдаа, зөрчил илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 1109.4 сая төгрөгийн 30 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 111.8 сая төгрөгийн 11 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баян-Өлгий аймгийн Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчил илрээгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар цалингийн зардал болон бусад зардлуудыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 5.1 Төлбөрийн акт

Байхгүй

#### 5.2 Албан шаардлага

Байхгүй

#### 5.3 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Баян-Өлгий аймгийн Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								